



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 540

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, техник, технологи болон хэрэглээний хоцрогдолд орж зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон хавсралтад заасан нийт 909,098,075.9 (есөн зуун есөн сая ерэн найман мянга далан таван төгрөг ерэн мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 283,739,070.69 (хоёр зуун наян гурван сая долоон зуун гучин есөн мянга далан төгрөг жаран есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, барилга, байгууламжийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үйлдвэрийн газрын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Акталсан барилга, байгууламжийг буулгаж, газрыг нөхөн сэргээх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001029



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 16 ны өдрийн
540 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮТЭГЭЛТЭЙ
АКТАЛЖ ДАНСНААС БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг, 2019.09.30)
	Дулааны цахилгаан станц						
1	Насосны станцын барилга	31.10.2014	м.кв	167.3	192,518,638.70	17,096,970.70	175,421,668.00
2	Харуулын будка	30.11.2005	м.кв	9	3,414,669.00	1,626,520.50	1,788,148.50
3	Градерен /хөргөх цамхаг/	31.12.2013	ш	1	277,012,312.00	96,608,044.03	180,404,267.97
4	Хөргөх цамхаг Градерен /град-400/ Ил уурхай	31.12.2009	ш	4	230,247,386.20	103,496,200.00	126,751,186.20
5	Диспетчерийн пункт	01.12.1999	м.кв	90	189,778,633.00	55,337,504.04	134,441,128.96
6	Хүдэр жигнэх жин	01.05.1980	ш	1	16,126,437.00	9,573,831.42	6,552,605.58
					909,098,075.90	283,739,070.69	625,359,005.21
Нийт дүн					(Есөн зуун есөн сая ерэн найман мянга далан таван төгрөг ерэн мөнгө)	(Хоёр зуун наян гурван сая долоон зуун гучин есөн мянга далан төгрөг жаран есөн мөнгө)	(Зургаан зуун хорин таван сая гурван зуун тавин есөн мянга таван төгрөг хорин нэгэн мөнгө)